ИЙСТ-ИЙГЛ ББСБ, ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ
2022 оны 12 сарын 31

Улаанбаатар хот

2023 он

АГУУЛГА

1 Хараат бус аудиторын тайлан 1-2

2 Аудитлагдсан санхүүгийн тайлан 3-4

2.1 Санхүүгийн байдлын тайлан 3

2.2 Орлого үр дүнгийн тайлан 3

2.3 Өмчийн өөрчлөлтийн тайлан 4

2.4 Мөнгөн гүйлгээний тайлан.....4

3 Санхүүгийн тайлангийн тодруулга 5-7

“ЭНИЧ АУДИТ” ХХК
Аудитын компани

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

ИЙСТ-ИЙГЛ ББСБ, ХХК-ИЙН УДИРДЛАГАД

Санхүүгийн Тайлангийн Аудитын Талаарх Тайлан

Дүгнэлт

Бид 2022 оны 12-р сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлого, үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн Ийст-Ийгл ББСБ, ХХК-ийн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар Ийст-Ийгл ББСБ, ХХК-ийн 2022 оны 12-р сарын 31-ээрх санхүүгийн байдал, тухайн жилийн санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээг Сангийн яам болон Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан заавар, журмын дагуу үнэн зөв толилуулж байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага гэсэн хэсэгт харуулав. Бид Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрэм-ийг санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой зохих ёс зүйн шаардлагуудын дагуу **Компаниас** хараат бус байх ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой гэж итгэж байна.

Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн Тайланд хүлээх Үүрэг Хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чахал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах Компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийлэлээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ анги эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм.

АОУС–ын дагуух аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шүүмж ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх хандалгыг баримтлан ажилладаг.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад аудитын илэрсэн томоохон асуудлуудаар засаглах эрх бүхий этгээдүүдтэй харилцдаг.

Засаглах эрх бүхий этгээдүүдтэй харилцсан асуудлуудаас тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн нөлөөтэй асуудлуудыг тодорхойлж тэдгээр асуудлаа аудитын гол асуудлууд гэж үзэж аудиторын тайландаа тодорхойлдог.

Аудитын тайлангийн хэрэглээ

Энэхүү тайлан нь Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох хувьцаа эзэмшигчийн хүсэлтийн дагуу зөвхөн компанийн хувьцаа эзэмшигчид зориулагдсан ба аливаа нэгэн өөр зорилго агуулаагүй болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд бусад этгээдийн өмнө үүрэг хариуцлага хүлээхгүй болно

“ЭНИЧ АУДИТ” ХХК-ийн
Захирал

Г.Чинтуяа (МНБ, Аудитор)

СБД, Сөүл гудамж 2-р хороо,Модуун цамхаг 502 тоот,
Улаанбаатар хот, Монгол улс
Утас: 976-70-002115, 91918420
Факс: 976-70-002115
Емэйл: enichaudit@gmail.com

2023 оны 3 сарын 31

ИЙСТ ИЙГЛ ББСБ, ХХК
АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
2022 оны 12-р сарын 31-ний өдөр

/төгрөг/

	Тэмдэглэгээ	2021	2022
ХӨРӨНГӨ			
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ			
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	3	1,736,729,600.00	2,285,908.38
Зээл /цэвэр /	4	-	2,035,000,000.00
Бараа материал	5	1,306,200.00	1,306,190.00
Нийт эргэлтийн хөрөнгийн дүн		**1,738,035,800.00**	**2,038,592,098.38**
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ			
Үндсэн хөрөнгө	6	10,356,400.00	8,554,212.17
Нийт эргэлтийн бус хөрөнгийн дүн		**10,356,400.00**	**8,554,212.17**
Нийт хөрөнгийн дүн		**1,748,392,200.00**	**2,047,146,310.55**
ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР			
Өр төлбөр			
Богино хугацаат өр төлбөр			
Дансны өглөг	7	2,878,800.00	2,978,740.36
Татвар, НДШ-ийн өглөг	8	3,783,300.00	903,000.04
Богино хугацаат өр төлбөрийн дүн		**6,662,100.00**	**3,881,740.40**
Нийт өр төлбөрийн дүн		**6,662,100.00**	**3,881,740.40**
Эзэмшигчдийн өмч			
Эзэмшигчдийн өмч	9	1,657,000,000.00	1,957,000,000.00
Хуримтлагдсан ашиг	**10**	**84,730,100.00**	**86,264,570.15**
Тайлант үеийн ашиг		-	1,381,132.04
Өмнөх үеийн ашиг		-	84,883,438.11
Эзэмшигчдийн өмчийн дүн		**1,741,730,100.00**	**2,043,264,570.15**
Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн		**1,748,392,200.00**	**2,047,146,310.55**

ИЙСТ ИЙГЛ ББСБ, ХХК
АУДИТЛАГДСАН ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН
2022 оны 12-р сарын 31-ний өдөр

/төгрөг/

	Тэмдэглэгээ	2022
Хүүгийн орлого	10	35,385,290.00
Цэвэр хүүгийн орлого		**35,385,290.00**
Хүүгийн бус зардал	11	33,850,698.84
Цэвэр хүүгийн бус зарлагын дүн		**(33,850,698.84)**
Болзошгүй эрсдлийн сан байгуулахаас өмнөх үйл ажиллагааны ашиг		**1,534,591.16**
Үндсэн үйл ажиллагааны ашиг		**1,534,591.16**
Татвар төлөхийн өмнөх ашиг		**1,534,591.16**
Орлогын албан татварын зардал	12	153,459.12
Цэвэр ашиг		**1,381,132.04**

Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг мөн болно

ИЙСТ ИЙГЛ ББСБ, ХХК

АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2022 оны 12-р сарын 31-ний өдөр

/төгрөг/

	Эзний өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2021 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл	**1,657,000,000.00**	**84,730,100.00**	**1,741,730,100.00**
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт		153,338.11	**153,338.11**
Хувь нийлүүлсэн хөрөнгийн өсөлт	300,000,000.00		**300,000,000.00**
Тайлант үеийн цэвэр ашиг		1,381,132.04	**1,381,132.04**
2022 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл	**1,957,000,000.00**	**86,264,570.15**	**2,043,264,570.15**

ИЙСТ ИЙГЛ ББСБ, ХХК

АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2022 оны 12-р сарын 31-ний өдөр

/төгрөг/

	2022
Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	**(4,069,443,691.62)**
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	**35,385,255.00**
Хүүгийн орлого	35,385,255.00
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	**4,104,828,946.62**
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгаа	2,035,000,000.00
Бусад зардал	2,069,828,946.62
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	**300,000,000.00**
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн орлого	**300,000,000.00**
Хувь нийлүүлсэн хөрөнгийн өсөлт	300,000,000.00
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	**(1,734,443,691.62)**
МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	**1,736,729,600.00**
МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	**2,285,908.38**

Санхүүгийн тайлангийн тодруулга
2022 оны 12-р сарын 31

1. Байгууллагын мэдээлэл

Ийст-Ийгл ББСБ, ХХК нь 2009 онд Санхүүгийн зохицуулах хорооноос зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авч үйл ажиллагаагаа явуулж байна.
Компанийн гэрчилгээний дугаар 000266301
Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар ТЗ 101/141
Регистрийн дугаар 5297826

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого

а. Санхүүгийн тайлагнал

Ийст-Ийгл ББСБ, ХХК-ийн удирдлага нь санхүүгийн тайлангаа Сангийн яам болон Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан заавар журмын дагуу бэлтгэж, Монгол улсын татвар, нийгмийн даатгал болон бусад хууль тогтоомжийг мөрдөж, нягтлан бодох бүртгэлээ хөтөлдөг.

б. Санхүүгийн тайланг бэлтгэсэн байдал

Тус компани нь нягтлан бодох бүртгэлээ "excel" програм ашиглан хөтөлдөг.

в. Тасралтгүй үйл ажиллагааны зарчим

Ийст-Ийгл ББСБ, ХХК–ийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа бөгөөд цаашид хэвийн үргэлжлүүлнэ гэсэн төсөөлөлд үндэслэн, тасралтгүй үйл ажиллагааны зарчмаар санхүүгийн тайлангаа бэлтгэдэг.

г. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Байгууллагын мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө нь касс, банканд байршуулсан мөнгөн хөрөнгөөс бүрддэг.

д. Авлага,Зээл

Авлагыг хүлээн авахаар урьдчилан тооцсон цэвэр боломжит үнэ цэнэ буюу төлөгдөх боломжтой дүнгээр бүртгэдэг. Зээлийг журмын дагуу ангилан эрсдлийн сан байгуулан цэвэр дүнгээр илэрхийлнэ.

е. Үндсэн хөрөнгө

Өртөг. Үндсэн хөрөнгийг хуримтлагдсан элэгдэл хассан цэвэр дүнгээр толиллуулдаг. Үндсэн хөрөнгийн анхны өртөг нь худалдан авсан үнэ, тухайн хөрөнгийг зориулалтын байршил, нөхцөлд ашиглалтанд оруулахтай холбогдсон бусад зардлаас бүрдэнэ.
Элэгдэл. Үндсэн хөрөнгийн элэгдлийг ашиглагдах хугацааны туршид шулуун шугамын аргаар байгуулдаг.

ж. Хүүгийн орлого

Орлого нь хүлээн авсан, эсвэл авахаар хүлээгдэж буй бодит үнэ цэнээр хэмжигддэг ба нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу аккруэл сууриар бүртгэдэг. Үндсэн үйл ажиллагааны орлого нь зээлийн хүүгээс бүрдэнэ.

з. Үндсэн үйл ажиллагааны зардал

Нийт үйл ажиллагааны зардал нь үйл ажиллагааны үндсэн зардлууд болон ажиллагсдын цалин, нийгмийн даатгалын зардал, ашиглалтын болон засвар үйлчилгээний зардал, байгууллагын үндсэн үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай бусад зардлуудаас бүрдэнэ.

и. Татвар, нийгмийн даатгалын шимтгэл

Байгууллага нь ААНОАТ, ХХОАТ, НДШ-ийг хуульд заасан хувь хэмжээний дагуу тооцон тайлагнаж, татварын байгууллагатай тооцоо хийдэг.

й. Тайлагналын дараах үйл явдал

2022 оны 12 сарын 31- ний өдрөөс дуусвар болсон жилийн санхүүгийн тайланг бэлтгэснээс хойш санхүүгийн тайланд нөлөө үзүүлхүйц үйл явдал гараагүй.

3.МӨНГӨ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

	2021	2022
Касс дахь бэлэн мөнгө /төгрөг/	1,699,394,064.56	-
Касс дахь бэлэн мөнгө /гадаад валют/	36,656,835.10	-
Банк дахь харилцах /төгрөг/	201,949.32	2,285,908.38
Банк дахь харилцах /гадаад валют/	476,751.02	-
Дүн	**1,736,729,600.00**	**2,285,908.38**

4.ЗЭЭЛ

	2021	2022
Хэвийн зээл	-	2,035,000,000.00
Дүн	**-**	**2,035,000,000.00**

5.БАРАА МАТЕРИАЛ

	2021	2022
Материал, үнэ бүхий зүйл	1,262,200.00	1,262,190.00
Бусад	44,000.00	44,000.00
Дүн	**1,306,200.00**	**1,306,190.00**

6.ҮНДСЭН ХӨРӨНГӨ

	2021	2022
Тавилга, эд хогшил	10,038,600.00	10,038,600.00
Хуримтлагдсан элэгдэл	(7,570,029.88)	(7,570,029.88)
Компютер, техник хэрэгсэл	30,795,521.00	30,795,521.00
Хуримтлагдсан элэгдэл	(22,907,691.12)	(24,709,878.95)
Дүн	**10,356,400.00**	**8,554,212.17**

7. ДАНСНЫ ӨГЛӨГ

	2021	2022
Дансны өглөг	1,770,200.00	2,149,740.36
Цалингийн өглөг	1,108,600.00	829,000.00
Дүн	**2,878,800.00**	**2,978,740.36**

8.ТАТВАРЫН ӨГЛӨГ

	2021	2022
ХХОАТ өглөг	-	423,000.00
НДШ-ийн өглөг	3,783,300.00	480,000.04
Дүн	**3,783,300.00**	**903,000.04**

9.ЭЗНИЙ ӨМЧ

	2021	2022
Энгийн хувьцаа	1,657,000,000.00	1,957,000,000.00
Хуримтлагдсан ашиг	**84,730,013.99**	**86,264,570.15**
Тайлант үеийн ашиг		1,381,132.04
Өмнөх үеийн ашиг		84,883,438.11
Дүн	**1,741,730,013.99**	**2,043,264,570.15**

10.ХҮҮГИЙН ОРЛОГО

	2021	2022
Хүүгийн орлого	260,000.00	35,385,290.00
Дүн	**260,000.00**	**35,385,290.00**

11.ХҮҮГИЙН БУС ЗАРДАЛ

	2021	2022
Цалингийн зардал	18,000,000.00	24,000,000.00
Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэл	2,250,000.00	3,000,000.00
Аудитын төлбөр, мэргэжлийн үйлчилгээ	800,000.00	800,000.00
Зохицуулалт үйлчилгээний хураамж	2,200,000.00	2,200,000.00

Ашиглалтын зардал	951,483.16	951,483.16
Үндсэн хөрөнгийн урсгал засвар, борлуулалтын үйл ажиллагааны зардал	1,802,221.99	1,802,221.99
Харуул, хамгаалалтын зардал	528,000.00	528,000.00
Харилцаа холбоо, интернет	361,145.00	361,145.00
Шимтгэлийн зардал	95,142.90	95,142.90
Автоматжуулалттай холбоотой урсгал зардал	90,462.00	90,462.00
Бичиг хэргийн зардал	20,000.00	20,000.00
Бусад зардал	-	2,243.79
Дүн	**27,098,455.05**	**33,850,698.84**

12.ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР

	2021	2022
Орлогын албан татварын зардал	-	153,459.12
Дүн	**-**	**153,459.12**